

**Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн алдагдал,
түүнд нөлөөлж буй хүчин зүйлс**

*Удирдсан багши **Б.Мөнхжаргал**,
МУИС-ийн ЭЗС-ийн багши, магистр,
Х.Айжсан, МУИС-ийн ЭЗС-ийн хүн ам зүйн
4-р ангийн оюутан*

Энэхүү судалгааны зорилго нь Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох явдал байв.

Сүүлийн 10 гаруй жилид Монгол улсын хүн амын насын бүтэц харьцангуй тааламжтай нөхцөлд байгаа ч тэтгэврийн даатгалын сангийн алдагдал жилээс жилд нэмэгдэж түүнийг нөхөх зорилгоор улсаас олгож буй татаас мөн өсч байна. Түүнчлэн хөдөлмөрийн насын хүн амын хувь өссөнтэй холбоотойгоор тэтгэвэр авагчдаасаа даатгуулагчдын тоо илүү өсч байгаа хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буурахгүй байсаар байна. Эдийн засгийн талаас авч үзвэл эдийн засгийн идэвхтэй хүн амын хувь 1995 оноос хойши байнга нэмэгдэж ирсэн ч нийт хүн амын дөнгөж гуравны нэг гаруй хувийг эзэлж байгаа ба тэдгээр хүмүүс бүрэн хэмжээгээр тэтгэврийн даатгалд хамрагдаж чадахгүй байна. Мөн манай улсын ажиллагасдын багагүй хувийг эзэлдэг хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон малчид сайн дурын даатгалд хамрагдах боломжтой байгаа ба тэдний энэ төрлийн даатгалд хамрагдсан байдал маш хангалтгүй байна. Эдгээр нөхцлийг нь Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн орлогын бурдэлтэд сөргөөр нөлөөлж, цаашилбал алдагдал буурахгүй байхад нөлөөлж байна. Бодлогын талаас нь дүгнэвэл, манай улсын хүн амын тэтгэвэрт гарах насын талаарх хуулийн заалт ижил түвшингийн хөгжилтэй орнуудынхтай ойролцоо байгаа хэдий ч янз бурийн шалтгаанаар эрт тэтгэвэрт гарах хандлага өндөр байна. Нөгөө талаас, Монголд эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 6 орчим жилээр доогуур байгаа хэдий ч тэтгэвэрт гарч буй дундаж нас нь 9 жилээр орой байгаа нь харьцангуй тэнцвэргүй үзүүлэлт мөн. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага хугацаанд шимтгэл төлж байгаа боловч удаан хугацаанд тэтгэвэр авч байгаа нь хуваарилалт шударга бус байгааг харуулж байна. Тэтгэврийн бодлого “хуваарилалтын тогтолцоо”-оос “хурийтлалын зарчим бүхий тогтолцоо” руу шилжсийж байгаа хэдий ч хурийтлалын тогтолцоо нь тэтгэврийн шимтгэлийг хийсвэрээр хурийтлуулж байгаа тул жинхэнэ утгаараа бүрэлдэж чадахгүй байна. Түүнчлэн тэтгэврийн хэмжээг тогтоох арга нь иргэний төлсөн шимтгэлээсээ бус, харин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдаатай байгаа нь тэтгэврийн даатгалын сангийн орлого өсөөгүй байхад зарлага өсөх өөр нэг шалтгаан болж байна.

Тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг бууруулахад: Тэтгэврийн даатгалын санд даатгуулагчдын хамрах хүрээг өргөтгөх; Үүний тулд, тухайлбал малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан тусгай нэр төрлийн тэтгэврийн даатгал гаргах замаар тэдний даатгалд хамрагдах байдлыг нэмэгдүүлж болох юм. Түүнчлэн нэг хүнд ногдох тэтгэврийн хэмжээг бууруулахгүйгээр тэтгэврийн даатгалын сангийн зарлагыг багасгах; Үүний тулд, тухайлбал эмэгтэйчүүдийн тэтгэвэр тогтоолгох насыг аажмаар нэмэгдүүлэх гэх мэт бодлогын зоригтой алхмуудыг хийж болно. Цаашлаад тэтгэврийн хэмжээг тогтоох аргачлалаа сайжруулах; Тухайлбал, тэтгэврийн доод хэмжээг шууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй биш, харин инфляции хэсэглээний нийтийн индикаторийн нялчнуулан тогтоох шалтглагатай

Үндэслэл

Сүүлийн гучаад жилийн тэргээгээс хөгжингүй улс орнуудад насжилтын үйл явц эрчимжих хандлагатай болсон ба хөгжиж байгаа орнуудад ч ирэх 10 жилээс нэмэгдэх төлөвтэй байгаа талаар НҮБ-ын болон бусад судалгаа, шинжилгээний тайлан,

мэдээллүүд мэдээлэх болжээ. Насжилтыг даган улс орны макро болон микро түвшинд олон шинэ шинэ өөрчлөлт, үр дагаврууд гарч байгаагийн нэг нь улс орнуудын Засгийн газрын нийгмийн хамгаалал, тэр дундаа тэтгэврийн төлөвлөлтийн асуудалд ихээхэн бэрхшээл учирч буй явдал билээ. Эдийн засгийн хөгжлийн хүрсэн түвшингээр дэлхийд тэргүүлж буй улс орнуудад эхнээсээ аль хэдийн тохиолдоод буй энэ бэрхшээлийг шийдвэрлэх, түүнээс урьдчилан сэргийлж болох арга замуудыг анхааран эрэлхийлж байна.

Дэлхийн ихэнх орнуудад хүн ам зүйн шилжилт буюу төрөлтийн түвшин буурч, дундаж наслалт нэмэгдэх үйл явц явагдснаар хүн амын насны бүтцэд нь өөрчлөлт ордог. Үүнийг даган улс орнуудын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөлтөд ч мөн ихээхэн өөрчлөлтүүд ордог. Тухайлбал, хүн амын насны бүтэц харьцангуй залуу байгаа улс орнуудад боловсрол, эрүүл мэндийн, харин хөгшин бүтэцтэй орнуудын хувьд нийгмийн хамгааллын асуудлууд онцгой анхаарал татаж байдаг. Өөрөөр хэлбэл, насны бүтцийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн зах зээл, хадгаламж, хөрөнгө оруулалт, татвар, тэтгэврийн төлөвлөлт гэх мэт асуудлуутай салшгүй холбоотой байдаг билээ. Хүн ам насжихын хэрээр улс орнуудад нийгмийн хамгаалал, түүн дотроо тэтгэврийн зардал ихээхэн нэмэгддэг ба нийгмийн халамж, үйлчилгээг чадварлаг зохион байгуулах хэрэгцээ шаардлага тавигдаж байна.

Монгол улсын хувьд хүн амын насны бүтэц харьцангуй залуу, насжилт явагдаагүй байгаа хэдий ч тэтгэврийн төлөвлөлтийн асуудал багагүй анхаарал татаж байна. Тэтгэврийг үндсэнд нь улсын төсвөөс олгож байсан хуучин тогтолцоог 1995 оноос өөрчилж, “Нийгмийн даатгалын багц хууль” батлагдан гарч түүнийг мөрдөх болоод 11 жил боллоо. Уг хуулийн дагуу ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлээс тэтгэвэр олгох буюу орлогоороо зарлагaa нөхөх “хуваарилалт”-ын зарчимд шилжсэн юм. Энэхүү хуваарилалтын зарчим нь хүн амын дийлэнх хэсэг нь залуу, дундаж наслалт нь тийм ч өндөр биш, ажилгүйдэл багатай, даатгуулагч тэтгэвэр авагчийн харьцаа тааламжтай орнуудад илүү тохиромжтой байдаг. Тэгвэл манай орны хувьд тэтгэврийн даатгалын сан нь дээрх тогтолцоонд шилжсэн цагаасаа орлогоороо зарлагaa нөхөж чадахгүй, алдагдалтай байсан ба улсаас шууд татаас авсаар ирсэн. Энэхүү сан нь Нийгмийн даатгалын багц хуульд заагдсан бусад бүх төрлийн (тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал, ажилгүйдлийн, эрүүл мэндийн) сангүүд дотроос алдагдалтай байгаа ганцхан сан юм. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буюу зарлагaa нөхөх зорилгоор улсаас авч байгаа нийт татаас нь 1995 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 1.3 хувийг эзэлж байсан бол 2005 он гэхэд 1.95 буюу ойролцоогоор 2 хувийг эзлэх болсон. (*Нийгмийн даатгалын сангүүдийн орлого зарлагын 1995-2005 оны тайлан тэнцэл*).

Тэтгэврийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож зах зээлийн нөхцөлд илүү тохиромжтой болгох үүднээс 1999 оноос “Нэрийн дансны тогтолцоо”-нд шилжсэн. Өнөөгийн байдлаар Монгол улс хуваарилалт-хуримтлалын хосолсон тогтолцоо уруу шилжих шилжилтийн үедээ байгаа ба уг тогтолцоогоор даатгуулагчийн шимтгэлийг тусгай дансанд хуримтлуулах, хэмжээг нь нэмэгдүүлэх замаар түүний нийт оруулсан хувь нэмрийг үндэслэн тэтгэвэр олгох юм. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ даатгалын сангийн зарим хэсгийг өнөөгийн тэтгэвэр авагчдад зарцуулах бөгөөд үлдэх хэсгийг нь эргэлтэнд оруулж өсгөх зарчмыг баримтлах ажээ. Манай нэрийн

дансны тогтолцоог одоохондоо хийсвэр хуримтлалын тогтолцоо гэж болох ба даатгуулагчийн төлсөн шимтгэл нь бодитойгоор банкны харилцах дансанд хадгалагдаж чадахгүй байна (НХХЯ, 2005). 2004 оны байдлаар манай улсад нэрийн данс нээлгэсэн байх ёстой хүмүүсийн 44.2 хувь нь буюу 458.9 мянган даатгуулагч нэрийн данс нээлгүүлсэн байв. 2005 оны 1 дүгээр сарын 1-ны байдлаар нийт нэрийн дансны эхний үлдэгдэл болон төлсөн шимтгэл 284 тэрбум төгрөг ба үүнд 3152.7 сая төгрөгийн хүү тооцжээ. Хэдийгээр хуваарилалтын тогтолцоонос нэрийн дансанд шилжсэн ч дансны үлдэгдэл болон хүүгээ хийсвэрээр тооцож байгаа нь ирээдүйн тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг улам нэмэгдүүлж, улсын эдийн засгийн байдалд илүү ачаалал үзүүлж болох юм.

Хүн ам зүйн талаасаа сонирхол татаж байгаа зүйл нь нийгмийн даатгалын одоогийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн цагаас хойшхи хугацаанд нийт хүн амд эзлэх хөдөлмөрийн насны хүн амын хувь болон даатгуулагч-тэтгэвэр авагчийн харьцаа тогтмол өссөөр ирсэн явдал юм. Тухайлбал, 1990 онд нийт хүн амын 52.6 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам байсан бол 1995 онд 56.2 хувь, 2005 онд 62 хувь болж нэмэгдсэн байна. Мөн 1995 онд 100 тэтгэвэр авагчид 144 даатгуулагч ногдож байсан бол 2005 оны байдлаар уг үзүүлэлт 251 болж өсчээ. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж, даатгуулагч нь тэтгэвэр авагчаасаа илүү хурдтай өссөөр байхад тэтгэврийн даатгалын сан алдагдалтай хэвээр байсаар байгаа явдал нь анхаарал татаж байна.

Нөгөөтэйгүүр 2005 онд тэтгэврийн насны буюу 60-аас дээш насны хүн ам нийт хүн амын 5.5 хувийг эзэлж байгаа (УСГ, 2005) ба 2000 оны Хүн ам орон сууцны тооллогын мэдээнд үндэслэн хийсэн Үндэсний Статистикийн Газрын хэтийн тооцооны дунд хувилбараар 2025 он гэхэд энэ хувь 11 болж 2 дахин өсөх хандлагатай байна. Мөн хүн амын дундаж наслалт 2005 онд эрэгтэйчүүдийнх 61.6 жил, эмэгтэйчүүдийнх 67.7 жил байсан ба 20 жилийн дараа буюу 2025 онд эрэгтэйчүүдийн хувьд 70 жил, эмэгтэйчүүдийн хувьд 74 жил хүрэх төлөвтэй байна. Ийнхүү, нэг талаас тэтгэврийн насны хүн амын хувийн жин нэмэгдэж, нөгөө талаас дундаж наслалт нэмэгдсэнээр тэтгэвэр авагчдын тэтгэвэр авах хугацаа уrtsах тул ирээдүйд тэтгэврийн даатгалын сангийн алдагдлын бууралтад хүн ам зүйн талаас одоогийнх шиг таатай нөхцөл бүрдэж чадахгүй гэж үзэж болохоор байна.

Монгол улсад тэтгэврийн даатгалын сангийн алдагдлын шалтгааныг олон талаас нь нарийвчлан судалсан ажлууд хомс байгаа ба гадны экспертуудтэй хамтарсан цөөн тооны цомхон судалгаанууд байна. Тэдгээрт тэтгэврийн сангийн алдагдлыг эдийн засгийн бодлого буюу тэтгэврийн тогтолцоо, тэтгэвэр олгох аргачлал талаас нь илүүтэй судалсан байна. Иймд, Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн алдагдлын өнөөгийн байдал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг олон талаас нь нарийвчлан судлах шаардлагатай байгаа юм.

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү ажлын гол зорилго нь Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох явдал юм. Уг зорилгын хүрээнд дараах ***зорилтуудыг*** дэвшүүлж байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангийн алдагдлын байдлыг судлах
- Тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нөлөөлж буй

- Хүн ам зүйн
- Эдийн засгийн
- Бодлогын хүчин зүйлсийг шинжлэх зэрэг багтана.

Судалгааны таамаглал

Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, ачааллын талаар өмнө хийгдсэн судалгааны ажлуудаас үндэслэн дараах таамаглалуудыг дэвшүүллээ. Үүнд:

- ✓ Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь хүн амын насны бүтцээс хамаарна. Үүнд, тэтгэврийн насны хүн амын хувийн жингээс шууд, хөдөлмөрийн насны хүн амын хувийн жингээс урвуу хамаарна.
- ✓ Хөдөлмөр оролцооны түвшин хангалтгүй байгаа нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нөлөөлж байна.
- ✓ Хөдөлмөрийн зах зээлд хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад зонхицаж байгаа нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нөлөөлж байна.
- ✓ Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буурахгүй байгаа нь бодлогын хүчин зүйл буюу тэтгэврийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлж байгаа зарчимтай холбоотой.

Арга зүй, аргачлал

A. Шинжилгээний хүрээ

Шинжилгээнд тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг хамаарах хувьсагчаар авсан ба түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг хүн ам зүйн, эдийн засгийн болон төр засгийн бодлого/зохицуулалтын хүчин зүйлс гэсэн гурван хэсэг болгон авч үзсэн. Эдгээр хүчин зүйлсийн шинжилгээний хүрээг Бүдүүвч 1-д дэлгэрэнгүй харуулав.

Бүдүүвч 1. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал ба түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээний хүрээ

Хүн ам зүйн хүчин зүйл

- Нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь
- Нийт хүн амд тэтгэврийн насны хүн амын эзлэх хувь
- Хүн ам зүйн ачаалал

Эдийн засгийн хүчин зүйл

- Хөдөлмөр идэвхийн ерөнхий коэффициент
- Хөдөлмөр оролцооны тусгай коэффициент
- ХАА-н салбарт ажиллагсдын хувь
- Ажил олгогчийн өсөлт
- Даатгуулагчийн өсөлт
- Өндөр настны тэтгэвэр авагчийн өсөлт

Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал

- Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал ДНБ-д эзлэх хувиар
- Алдагдлын өсөлт

Бодлогын хүчин зүйл

- Тэтгэвэр тогтоох нас
- Татаас олголт
- Тэтгэврийн хэмжээг тогтоох

Б. Мэдээллийн эх үүсвэр

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хоёрдогч мэдээллийн эх үүсвэрүүдийг ашигласан болно. Үүнд, Монгол улсын хүн амын тооллогын болон бусад тайлан, мэдээллүүд, статистикийн жил тутмын эмхтгэлүүд, мөн Нийгмийн даатгалын сангудын орлого, зарлагын 1995-аас 2005 онуудын тайлан тэнцлүүд багтах юм.

Мэдээллийн хязгаарлагдмал байдал: Тэтгэврийн даатгалын сантай холбоотой тоо мэдээллүүд харьцангуй цөөхөн оноор, улсын дүнгээр, орлого, зарлагын бүтэц нь ерөнхий байдлаар өгөгдсөн байсан тул бүс нутгаар харьцуулан судлах гэх мэт дэлгэрэнгүй шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байв.

В. Аргачлал, ойлголт, тодорхойлолтууд

Судалгаанд Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн байдал, хандлагыг авч үзэхдээ 1995 оноос хойши мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Учир нь тэтгэврийн даатгалын талаар одоогийн мөрдөгдөж буй тогтолцоо нь 1994 онд Монгол улсад Нийгмийн даатгалын тухай багц хууль батлагдсанаар үйлчилж эхэлсэн ба холбогдох тоо мэдээллүүд нь ч мөн энэ үеэс хойш тайлан, мэдээгээр гардаг болсон.

Шинжилгээний гол үзүүлэлт болох тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага, алдагдлын тоо мэдээнүүдийг шинжилгээнд ашиглахдаа инфляцийн нөлөөг арилгах үүднээс 2000 оны зэрэгцүүлсэн үнэд шилжүүлэн тооцсон. Ингэхдээ оны үнээр тооцсон ДНБ-ийг зэрэгцүүлсэн үнэд шилжүүлсэн харьцааг ашиглав.

Энэхүү ажилд ашиглагдсан зарим гол ойлголт, тодорхойлолтуудыг доор харуулав.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын тухай хуулинд зааснаар, Нийгмийн даатгал нь иргэн /цаашид "даатгуулагч" гэх/ болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас бараад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн. Нийгмийн даатгалын төрөлд **тэтгэврийн даатгал**, тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал болон ажилгүйдлийн даатгал гэх мэт терлүүд багтана. Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байдаг.

Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал: Тэтгэврийн даатгалын сангийн орлогоос давсан зарлага буюу уг алдагдлыг нөхөх зорилгоор улсаас олгож буй татаас юм.

Хуваарилалтын тогтолцоо: Өнөөгийн шимтгэл төлөгчийн хөрөнгөөр ахмад настны тэтгэврийг олгодог, хуримтлуулсан хөрөнгийн нийт хэмжээг харгалзахгүйгээр тодорхой журам, зааврын үндсэн дээр тэтгэврийн хэмжээг нь тогтоож олгодог хуваарилалтын шинжтэй үйл ажиллагаа. Өөрөөр хэлбэл, орлогоороо зарлагаа нөхөх шинж чанартай тогтолцоо юм.

Хуваарилалт-хуримтлалын хосолсон тогтолцоо Энэ нь даатгуулагчийн шимтгэлийг тусгай дансанд хуримтлуулах, хэмжээг нь нэмэгдүүлэх замаар түүний нийт оруулсан

хувь нэмрийг үндэслэн тэтгэвэр олгох үйл ажиллагаа юм. Үүнийг хэрэгжүүлэхдээ даатгалын сангийн зарим хэсгийг өнөөгийн тэтгэвэр авагчид зарцуулах бөгөөд үлдэх хэсгийг нь эргэлтэд оруулж, өсгөж нэмэгдүүлэх зарчим баримталдаг.

Хөдөлмөрийн насны хүн ам: Хөдөлмөрийн насны хүн амыг олон улсын жишгээр 15-64 насны хүн ам гэж үздэг ба энэхүү судалгаанд хөдөлмөрийн насны хүн амыг Монгол улсын 15-59 насны хүн амаар төлөөлүүлэн авсан.

Тэтгэврийн насны хүн ам: “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” Монгол Улсын хуулинд “Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно” гэсэн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг харгалзан тэтгэврийн насны хүн амд 60 ба түүнээс дээш настай хүн амыг хамруулав.

Хүн ам зүйн ачаалал: Хөдөлмөрийн насны (15-59 насны) хүн амд ногдох хөдөлмөрийн бус насны (0-14 насны, 60 ба түүнээс дээш насны) хүн амын тоо

Насжилт: Нийт хүн амд залуу (15-аас доош насны) хүн амын эзлэх хувь багасч, хөгшин (60 ба түүнээс дээш насны) хүн амын эзлэх хувь өсөх үзэгдэл

Ажил олгогч: Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээд

Эдийн засгийн идэвхтэй хүн ам: Хүн амын хэрэгцээ шаардлага болсон бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоход оролцож буй болон оролцох чадвартай хүн ам. Үүнд ажиллагсад ба ажилгүйчүүд багтана.

Хөдөлмөрийн Идэвхийн Ерөнхий Коэффициент (ХИЕК): Нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь

Хөдөлмөр Оролцооны Тусгай Коэффициент (ХОТК): Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагсдын эзлэх хувь

1. Монгол улс дахь тэтгэврийн даатгалын сангийн өнөөгийн байдал

Энэ хэсэгт Монгол улсын нийгмийн хамгааллын системийн гол хэсэг болох тэтгэврийн даатгалын сан, түүний нийгмийн даатгалын санд эзлэх хувь, орлого бүрдэлт болон зарлагын байдлыг динамик хандлагаар нь авч үзэх болно.

1.1. Монгол улс дахь нийгмийн даатгалын байдал

Монгол улсад нийгмийн даатгалын одоогийн баримталж байгаа зарчим нь 1994 онд анх үүссэн ба түүнээс хойш төсвийн нийт урсгал зардлын дөрөвний нэг орчим хувийг эзэлсээр иржээ. Тухайлбал, 1995-2005 онуудад 21.4-27 хувийн хооронд хэлбэлзэж

ирсэн ба 2005 оны байдлаар 27 хувийг эзэлж байна. Түүнчлэн нийгмийн даатгалын зардал 2005 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 4 хувийг эзэлж байгаа нь бага орлоготой орнуудад 0.2-0.3 хувь байгаатай харцуулахад өндөр үзүүлэлт юм.

Монгол улс дахь одоогийн нийгмийн даатгал нь үүссэн цагаасаа хойш тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал болон ажилгүйдлийн даатгал гэсэн 5 төрлийн сангаар нийгмийн хамгааллын үйл ажиллагааг явуулж ирсэн. Эдгээр сангудын орлого, зарлагын үйл ажиллагааг Хүснэгт 1.1-д харуулав.

**Хүснэгт 1.1. МУ-ын нийгмийн даатгалын сангудын орлого, зарлага, 2000 оны зэрэгцүүлэх үнээр,
1995-2005 /сая.төгр/**

Нийгмийн даатгалын сангуд	Нийт	Үүнээс:				
		Тэтгэвэр	Эрүүл мэнд	Тэтгэмж	ҮОМ ШӨ	Ажилгүйдэл
1995	Шимтгэлийн орлого	32543.2	20327.5	7422.4	2365.1	1407.6
	Зарлага	40077.9	28317.2	10354.8	1376.8	29.1
	Зөryү, төгрөгөөр	-7534.8	-7989.7	-1322.1	988.2	1378.4
2000	Шимтгэлийн орлого	59793.9	38179.2	13259.5	3789.7	2683.8
	Зарлага	72538.8	53731.8	13854.1	2299.6	1997.0
	Зөryү, төгрөгөөр	-12744.9	-15552.6	-594.6	1490.1	686.8
	Зөryүний жил.дун.өсөлт	13.8	18.9			
2005	Шимтгэлийн орлого	73312.4	46658.4	15947.9	4803.4	3506.2
	Зарлага	90718.4	70458.7	13788.9	2954.9	2770.8
	Зөryү, төгрөгөөр	-17406.0	-23800.3	2158.9	1848.5	735.3
	Зөryүний жил.дун.өсөлт	7.3	10.6			


Эх үүсвэр: УНДЕГ, Нийгмийн даатгалын сангудын орлого, зарлагын 1995-2005 оны тайлан

Хүснэгтээс, бусад сантай харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сан ба тэтгэврийн даатгалын сангуд багагүй хугацаанд алдагдалтай явж ирсэн нь харагдаж байна. Харин даатгалын хамрах хүрээгээ өргөжүүлж чадснаар 2000 оноос эрүүл мэндийн даатгалын сан алдагдалгүй ажиллах болж, өнөөгийн байдлаар Монгол улсад тэтгэврийн даатгалаас бусад сангуд нь орлогоороо зарлагаа бүрэн нөхөж байна. Тухайлбал, 2000 оны зэрэгцүүлсэн үнээр тэтгэвэр болон эрүүл мэндээс бусад сангийн шимтгэлийн орлого нь зарлагаа нөхөх төдийгүй ашигтай байсныг 1995, 2000 оны тоонуудаас харж болно. Харин 2000 оноос хойш эрүүл мэндийн даатгалын сан алдагдалгүй болж, 2005 он гэхэд зарлагаа давсан 2158.9 сая төгрөгийн орлоготой болжээ.

Тэтгэврийн даатгалын санг авч үзвэл 1995-аас 2000 оны хооронд алдагдал нь жилд дунджаар 18.9 хувиар өсч байсан бол 2000-аас 2005 оны хооронд жилд дунджаар 10.6 хувиар өсчээ. Энэхүү алдагдлын жилийн дундаж өсөлтийн хурд нь нийт нийгмийн даатгалын сангийн алдагдлын жилийн дундаж өсөлтийн хурдаас 3-5 орчим пунктээр өндөр явж ирсэн байна.

Түүнчлэн тэтгэврийн даатгалын сангийн зардал нь нийгмийн даатгалын зардлын ихэнх буюу 70-аас илүү хувийг эзэлж байгаа нь тэтгэврийн даатгалын сангийн хамрах хүрээ хэр өргөн байгааг харуулж байгаа юм. Нийгмийн даатгалын нийт зардалд

тэтгэврийн даатгалын сангийн эзлэх хувь нь нийгмийн даатгалын тогтолцоо анх үүсэхэд буюу 1995-1996 онд 65-69 хувь байсан бол аажмаар өсөн 2005 он гэхэд нийгмийн даатгалын нийт зардлын 75 хувь буюу дөрөвний гурвыг эзлэх болсон байна (Зураг 1.1). 1995 оноос өнөөг хүртэлх 11 жилд хүн амын насны бүтэц эдийн засагт харьцангуй ашигтай байгаа ба энэ үед хэдийгээр огцом биш ч ийм өөрчлөлт гарсан нь анхаарал татахаар байгаа юм.



Эх үүсвэр: УНДЕГ, Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын 1995-2005 оны тайллан тэнцэл


Цаашид урт хугацаанд хүн амын насны бүтцэд гарах өөрчлөлттэй холбоотойгоор тэтгэврийн зардлын хамрах хүрээ улам өргөсөж болзошгүй, мөн тэтгэврийн даатгалын сан алдагдалтай байсаар байгаа нь тэтгэврийн даатгалын санг анхааран авч үзэх шаардлагатайг харуулж байгаа юм. Учир нь энэ сангийн алдагдлыг татаас хэлбэрээр улсын нэгдсэн төсвөөс олгож байгаа ба цаашид сангийн алдагдлыг бууруулахгүй бол улсын төсвийн ачааллаар дамжуулан улс орны эдийн засгийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй юм.

1.2. Монгол улс дахь тэтгэврийн даатгалын сан

Нийгмийн даатгал үүссэн цагаас эхлэн Монгол улсын тэтгэврийн даатгалын сан алдагдалтай үйл ажиллагаа явуулж ирсэн шалтгааныг тодруулахын тулд уг сангийн орлого бүрдэлт болон зарлагын байдлыг нарийвчлан судлах шаардлагатай.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого бүрдэлтийн байдлыг 1995-2005 оны хооронд авч үзвэл нийт зардлынхаа 18-37 хүртэл хувийг улсын төсвөөс татаас болгон авч байсан байна (Зураг 1.2). Зөвхөн 1997 онд л энэ үзүүлэлт 18.4 хувь байсан нь 11 жилийн хугацаан дахь хамгийн бага түвшинтэй үзүүлэлт байсан ба үүнээс хойш нийт орлогод татаасын эзлэх хувь жил ирэх тусам өсчээ. 2005 оны байдлаар тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд улсаас олгож буй татаас нь нийт орлогын 35.6 хувийг бүрдүүлсэн байна.

**Зураг 1.2. Тэтгэврийн даатгалын сангийн орлого, бүрдэж буй эх
үүсвэрээр /хувиар/**



Эх үүсвэр: УНДЕГ, Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 1995-2005 оны тайлан

Тэтгэврийн даатгалын санд улсаас олгож буй татаас нь тус сангийн орлогын 30-аас дээш хувийг бүрдүүлж байгаа бол энэхүү татаас нь эдийн засгийн гол үзүүлэлт болох ДНБ-д хэрхэн нөлөөлж байгааг Хүснэгт 1.2-т харуулав. Үүнд тэтгэврийн даатгалын зардал нь ДНБ-д эзлэх хувиараа буурч чадахгүй жил ирэх тусам өсч байгаа юм. Нөгөө талаас тэтгэврийн даатгалын сангийн орлогоосоо давсан зарлагыг нөхөхийн тулд улсаас олгож буй татаас буюу тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь мөн өсч байна. Тухайлбал, 1995 онд тэтгэврийн даатгалын зардал нь ДНБ-ний 3.2 хувь, татаас нь 1.3 хувийг тус тус эзэлж байсан бол 2005 оны байдлаар харгалзан 5.3 хувь ба 2 хувьолжээ.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого нь зарлагаа нөхөж чадахгүй байхад зарлага нь ДНБ-д эзлэх хувиараа жилээс жилд өссөөр байгаа нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буюу улсаас авах татаасыг улам нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Хүснэгт 1.2. Тэтгэврийн даатгалын сангийн зардал болон алдагдал, 2000 оны зэрэгцүүлсэн үнээр

ДНБ /сая.төг/	Тэтгэврийн даатгалын зардал /сая.төг/	Тэтгэврийн даатгалын алдагдал /сая.төг/	Тэтгэврийн даатгалын зардлын ДНБ-д эзлэх хувь	Тэтгэврийн даатгалын алдагдлын ДНБ- д эзлэх хувь
1995	886076.8	28317.2	11839.3	3.2
1996	906815.3	31927.9	9654.8	3.5
1997	942962.2	32342.9	5954.6	3.4
1998	976575.1	43128.0	10227.0	4.4
1999	1008002.0	42265.5	12963.0	4.2
2000	1018885.7	53731.8	14771.0	5.3
2001	1029189.5	54053.1	19334.0	5.3
2002	1070566.7	57407.4	21071.9	5.4
2003	1130061.3	61234.3	18903.6	5.4
2004	1251395.5	69811.5	27510.7	5.6
2005	1319269.5	70458.7	25741.6	5.3
				2.0

Эх үүсвэр: УНДЕГ, Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 1995-2005 оны тайлан,
УСГ, "Статистикийн эмхтгэл", 1998, 2000, 2005


2. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нөлөөлж буй хүчин зүйлс

Тэтгэврийн даатгалын сангийн үйл ажиллагаа нь хүн ам зүй, эдийн засаг болон бодлогын гэх мэт олон хүчин зүйлүүдээс шууд хамаарч байдаг. Тухайлбал, хүн амын насны бүтэц нь хөдөлмөрийн зах зээл ба хөдөлмөрийн насны дараах хүн ам зэрэгтэй салшгүй холбоотой бөгөөд үүнээс тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага гэсэн хоёр талыг бүрдүүлж байдаг даатгуулагч, тэтгэвэр авагчийн тоо хэмжээ тодорхойлогдож байдаг. Мөн эдгээр хүчин зүйлс нь тэтгэврийн хамрах хүрээ, зарцуулах хөрөнгийн хэмжээ, үргэлжлэх хугацаа зэргийг тодорхойлдог чухал ач холбогдолтой. Нөгөө талаар эдийн засгийн оновчтой бодлого явуулах нь тэтгэврийн даатгалын сан алдагдалгүй байхад чухал нөлөөтэй. Иймд судалгааны энэхүү хэсэгт Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нөлөөлж буй хүн ам зүй, эдийн засаг болон бодлогын хүчин зүйлсийг авч үзнэ.

2.1. Хүн ам зүйн хүчин зүйлс

Тэтгэврийн даатгалын сангийн орлого бүрдэлт болон зарлага нь хүн ам зүйн үзүүлэлт болох хүн амын насны бүтцээс шууд хамаардаг. Монгол улсын хувьд хүн амын насны бүтэц түүхэн цаг хугацаанд хэрхэн өөрчлөгдөж ирсэн, цаашид яаж өөрчлөгдөх эсэх нь ч тэтгэврийн даатгалын сангийн үйл ажиллагаанд шууд нөлөөлнө гэж болно.

Монголын хүн амын насны бүтцийн өөрчлөлт, хандлагыг авч үзвэл 20-р зууны дунд үеэс хойш хүн амын өсөлт оргил хэмжээндээ хүрч байсан үед ихээхэн залуужсан. Харин сүүлийн жилүүдэд хүн амын төрөлтийн түвшин эрс буурч, төрөлт өндөр үеийн хүүхдүүд хөдөлмөрийн насанд шилжин ирж байгаатай холбоотойгоор хүн амын насны бүтэц нь эдийн засагт ихээхэн таатай нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Насны бүтцийн энэхүү өөрчлөлтийг Зураг 2.1-д харуулсан хүн ам зүйн шилжилттэй уялдуулан тайлбарлаж болно.




Мэдээллийн эх үүсвэр: УСГ, “Монгол Улсын хүн ам ХХ-р зуунд” УБ, 2000

Зургаас харахад, Монголын хүн ам зүйн шилжилтийн эхний үе буюу төрөлт, нас баралтын түвшин аль аль нь доогуур үе 1950-иад оныг хүртэл үргэлжилжээ. Энэ үед хүн амын насны бүтэц нэлээд зохисгүй хэлбэртэй байсан. Шилжилтийн II үед нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амаа өсгөх талаар төрөөс явуулж эхэлсэн идэвхтэй бодлогуудын үр дүнд нас баралтын өндөр түвшин буурч, төрөлт нэмэгдэн “Хүн амын өсөлтийн тэсрэлт” явагдсанаар хүн ам залуужсан юм. Хүн ам хурдацтай өсч, залуужих энэхүү үйл явц 1980-аад оны сүүлч хүртэл үргэлжилсэн ба 1990 оны үеэс улс төр, эдийн засгийн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтийн нөлөөгөөр хүмүүсийн төрөлтөд хандах хандлага өөрчлөгдөж төрүүлэх хүүхдийн тоог эрс бууруулсан. Төрөлтийн энэ бууралт одоо ч үргэлжилсээр байгаа төдийгүй нас баралтын бууралтаас ч хурдан байсан юм. Тухайн үед хүн амын гадаад шилжих хөдөлгөөн бага байсан тул төрөлт, нас баралтын бууралт нь хүн амын насны бүтцэд ч нөлөөлж, нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь эрчтэй нэмэгдэж эхэлсэн ба өнөөгийн байдлаар сүүлийн 50 гаруй жилийнхээс хамгийн өндөр түвшинд хүрээд байна.

Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх нь хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээлгэгч буюу хүүхэд, өндөр настны тоо (хүн ам зүйн ачаалал)-г бууруулдаг. Ийнхүү хүн ам зүйн ачаалал буурч, доогуур түвшинд байх үзэгдлийг хүн ам зүйн шинжлэх ухаанд “Хүн ам зүйн цонхны үе” гэж нэрлэдэг билээ. Учир нь тэжээлгэгч хүмүүсийн тоо буурснаар хөдөлмөрийн насны хүн ам илүү их хадгаламж, хуримтлал үүсгэх боломжтой гэж үздэг. Энэ нь нэг талаас улс оронд санхүүгийн хөрөнгө оруулалт болдог бол нөгөө талаас хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин өндөр байх нь ажиллах хүчиний нөөц бололцоог бий болгодог юм. Хүн ам зүйн цонхны үед төр, засгаас оновчтой бодлого явуулж чадвал улс орны эдийн засагт өндөр өсөлт гарах боломжтой байдаг. Хүн ам зүйн цонхны үеэ сайн ашиглаж улс орноо хөгжүүлж чадсан жишээгээр Зүүн Азийн орнуудыг дурьдаж болох юм. Тухайлбал, хүн ам зүйн цонхны үе нь тохиолдож байсан үе буюу 1960-1999 онд

Өмнөд Солонгос нэг хүнд ногдох ДНБ-ээ 10 дахин нэмэгдүүлж чадсан байдаг. Мөн тэр үед Тайвань, Сингапур зэрэг улсуудад нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн дундаж өсөлтийн хурд 6 хувиас дээгүүр байсан нь тухайн үеийн Япон, Герман, АНУ гэх мэтийн хөгжингүй орнуудынхаас 2-3 дахин өндөр байжээ.

Манай улсын хувьд “Хүн ам зүйн цонхны үе” хүн ам зүйн шилжилтийн 3-р үе шатанд буюу 1990-ээд оны дундаас явагдаж эхэлсэн гэж болох ба энэ нь 1970-1980-аад оны төрөлтийн тэсрэлтийн үед төрсөн хүн ам бөөнөөрөө хөдөлмөрийн насанд ирж байгаа, нөгөө талаас хүн амын төрөлтийн түвшин буурсан хэвээр байгаатай холбоотой юм. Энэ хандлага судлаачдын үзэж байгаагаар 2020-иод он хүртэл үргэлжлэх төлөвтэй (Зураг 2.2) тул одоогоор хүн ам зүйн талаас Монголын эдийн засгийн хөгжилд өндөр өсөлт гарах боломжтой таатай нөхцөл бүрдээд байна гэж хэлж болно. Харин төрөлтийн бууралт одоогийнхоор үргэлжилбэл 2025 оноос цааш 1970-1980 оны үед төрсөн масс ихтэй хүн ам нэгэн зэрэг тэтгэврийн насанд шилжсэнээр хүн ам хөгшрөх хандлагатай болж ирээдүйд тэтгэврийн ачааллыг улам нэмэгдүүлэх магадлалтай юм.



Мэдээллийн эх үүсвэр: УСГ, “Монгол Улсын хүн ам ХХ-р зуунд” Улаанбаатар, 2000,


УСГ, “Статистикийн эмхтгэл” 2003, 2005.

Ийнхүү цонхны үе эхэлснээр тэтгэврийн насны хүн амын хувь харьцангуй багасч байгаа тул тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авах хүмүүсийн хувь ч пропорционалиар буурч, тэтгэврийн даатгалын сан алдагдалгүй байх боломжтой билээ. Гэвч тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буурч чадахгүй байгаа нь түүнд хүн ам зүйтгээс бусад хүчин зүйл гол нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

2.2. Эдийн засгийн хүчин зүйлс

Монгол улсад сүулийн жилүүдэд хүн ам зүйн талаас таатай нөхцөл бүрдсэн байхад тэтгэврийн сангийн алдагдал яагаад буурч чадахгүй байна гэдгийг тодруулахын тулд тэтгэврийн даатгалын сангийн орлого бүрдэлт болон зарлагыг эдийн засгийн гэж нэрлэж болох зарим хүчин зүйлстэй холбон авч үзье.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого бүрдүүлэгч тал: Тэтгэврийн даатгалын сангийн орлого бүрдэлтийг авч үзвэл, ажил олгогчоос ажиллагчийн цалингийн 19 хувьтай тэнцэх хэмжээгээр төлдөг шимтгэлийн 13.5 хувь, мөн ажиллагч өөрийн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээгээр төлдөг шимтгэлийн 5.5 хувь болон бусад эх үүсвэрээс бүрддэг. Эдгээрээс 2005 оны байдлаар ажил олгогч, төсөвт газар болон ажиллагчийн төлсөн шимтгэлүүд ихэнх буюу 60 хувийг бүрдүүлж байгаа боловч төвлөрсөн төсвөөс төлсөн шимтгэл буюу татаас аль ч эх үүсвэрийн бүрдүүлсэн шимтгэлээс илүү өндөр (37.2 хувь) хувийг эзэлж байна (Зураг 2.3). Харин сайн дурын даатгуулагчдын төлсөн шимтгэл дөнгөж 0.7 хувийг эзэлж байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм.



Мэдээллийн эх үүсвэр: УНДЕГ, Нийгмийн даатгалын сангудын орлого, зарлагын тайлан, 2005

Эдгээр нь Монгол улсад хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагаа тийм ч хангалттай бус байгаатай холбоотой байж болох юм. Иймд, тэтгэврийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрүүд дотроос хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой үзүүлэлтүүд нь сүүлийн жилүүдэд ямар чиг хандлагатай явж ирснийг авч үзье.

Зураг 2.4-т Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүдийг 1995-2005 оны динамикаар харуулав. Зургаас харахад, нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн ам сүүлийн 10 жилд хүн амын талаас илүү хувийг эзэлж байгаа ба 56.2-оос 62 хувь болж тогтвортой нэмэгдсэн байна. Харин хөдөлмөрийн идэвхийн ерөнхий коэффициент (ХИЕК) буюу нийт хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь бага зэрэг өсч байгаа боловч нийт хүн амын дөнгөж гуравны нэг гаруй хувийг л эзэлж байна. Эндээс, хөдөлмөрийн насанд хүрсэн хүмүүсийн талаас илүү нь эдийн засгийн идэвхгүй байгааг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл зах зээлд ажлын байр хомсдолтой байгаатай холбоотой Монгол улс өөрийнхөө ажиллах хүчиний нөөц бололцоог бүрэн ашиглаж чадахгүй байна гэж хэлж болно. Энэ байдал нь заавал даатгалд хамрагдах хүн амын хувь потенциал түвшингээсээ доогуур байж, тэтгэврийн даатгалын хамрах хүрээ бага байхад нөлөөлж байна.



Мэдээллийн эх үүсвэр: УСГ, “Статистикийн эмхтгэл” 2003, 2005.

Нөгөө талаас, хөдөлмөрийн насны хүн амын хувь болон эдийн засгийн идэвхтэй хүн амын хувийн жин бага багаар нэмэгдэж байгаа ч тэднийг бүрэн хэмжээгээр тэтгэврийн даатгалд хамруулж чадаж байгаа эсэхийг анхааран авч үзэх нь чухал. Үүнийг Монгол улсын хувьд 1995 оноос хойш авч үзвэл, хөдөлмөр эрхэлж буй хүн ам бүрэн хэмжээгээр даатгалд хамрагдсан он огт тохиолдоогүй байна. Одоогийн нийгмийн даатгал анх хэрэгжиж эхэлсэн ёе буюу 1995 онд хөдөлмөр эрхлэгчдийн 53.3 хувь нь нийгмийн даатгалд хамрагдаж байсан ба 2005 оны байдлаар 73.4 хувь нь хамрагджээ (Хүснэгт 2.1). Энэ хугацаанд даатгуулагчдын хувь 1997 онд 79.8 хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байгаа бөгөөд түүнээс хойш ахин энэ түвшиндээ хүрч чадаагүй байна.

**Хүснэгт 2.1. Монгол улсын хүн амын ажиллах хүчиний болон тэтгэврийн даатгалын сангийн зарим
үзүүлэлтүүд, 1995-2005**

Үзүүлэлт	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Ажиллагдсны тоонд даатгуулагчдын эзлэх хувь	53.3	73.5	79.8	76.5	76.5	77.7	75.8	62.7	68.8	71.2	73.4
Ажиллагдсны тоонд ХАА-н салбарт ажиллагдсны эзлэх хувь	46.1	46.5	48.9	49.7	49.5	48.6	48.3	44.9	41.8	40.2	-
Ажиллагдсны тоонд малчдын эзлэх хувь	-	-	-	-	-	-	-	44.7	40.8	38.9	-
100 тэтгэвэр авагчид ногдох даатгуулагчийн харьцаа	144	203	265	256	254	247	243	208	237	244	251

- Мэдээллийн хязгаарлагдмал байдлаас үүдэн тооцоогүй

Эх үүсвэр: УНДЕГ, Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 1995-2005 оны тайлан

УСГ, “Статистикийн эмхтгэл”, 1998, 2000, 2005

Манай улсад хөдөлмөр эрхэлж буй хүн ам нийгмийн даатгалд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа нь тэдний хөдөлмөр эрхэлж буй салбараас хамаарч байж болох юм. Учир нь Монгол улсад одоо мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын тухай багц хуулийн 4-р зүйлийн 2, 3-р хэсгүүдэд зааснаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллаагүй, хувиараа үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлж буй хүмүүс, малчид нийгмийн даатгалд даатгуулах эсэх, түүний ямар төрлийг сонгохоо өөрөө шийдвэрлэх эрхтэй байдаг байна. Гэтэл 1995-аас 2005 оны хооронд Монгол улсад нийт хөдөлмөр эрхлэгчдийн 40.2-өөс 49.7 хүртэл хувь нь хөдөө аж


ахуйн салбарт ажиллагсад байсан ба үүн дотроос 2004 онд нийт ажиллагсдад малчдын эзлэх хувь 38.9 байжээ.

Түүнчлэн МУ-ын Засгийн газраас 2003 онд батлан гаргасан “Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг”-ийн үндэслэл хэсэгт 2002 оны байдлаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 4 хувь нь л сайн дурын даатгалд хамрагдаж байна гэжээ. Гэтэл тухайн онд зохион байгуулалттай салбарт ажиллагсдын 87.4 хувь заавал даатгалд хамрагдсан байв. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэврийн даатгалд (нийгмийн даатгалд) сайн дураар даатгуулах эрхтэй төдийгүй сайн дураар даатгуулагчдын төлж буй нийт шимтгэл (11.5 хувь) нь заавал даатгуулагчийн төлөх шимтгэлийн (19-21 хувь) нийт дүнгээс 2 дахин бага, шимтгэл төлж буй орлогоо өөрсдөө тодорхойлдог байна.

Ийнхүү Монголд хөдөлмөр эрхэлж буй хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтын байдал тэдний хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээс ихээхэн хамаарч байгаа ба ажиллагсдын багагүй хувийг бүрдүүлдэг ХАА-н салбарт ажиллагсад, малчид нийгмийн даатгалд заавал хамрагддаггүй онцлогтой байна.

Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн даатгалд хамрагдалтын байдал ийнхүү маш доогуур байгаа нь нэг талаас даатгалын үйлчилгээ тэдэнд хүрч чадаагүй, нөгөө талаас хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан нийгмийн даатгалын тогтолцоу тэдний хөдөлмөр, үйлдвэрлэлийн онцлогтой зохицохгүй байгааг харуулж байж болох юм.

Зураг 2.5-д 1995-аас 2005 он хүртэл хугацаанд даатгуулагчдын бүтцэд ямар өөрчлөлт гарсан талаарх мэдээллийг харуулав.



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын сангруудын орлого, зарлагын 1995-2005 оны тайллан


Ерөнхийдөө, сайн дураар даатгуулагчдын хувь ихээхэн хангалтгүй байгааг зургаас харж болохоор байна. Нийт даатгуулагчдад сайн дурын даатгуулагчдын эзлэх хувь 1997 онд 33.3 хувьд хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол 2005 он гэхэд энэ нь 4.1 хувь болтол буурчээ. Нийгмийн даатгал нь 1995 оноос хэрэгжиж эхэлсэн ба 1996-

оос 1997 онуудад сайн дураар даатгуулах ажлыг эрчимтэйгээр сурталчилсны үр дүнд сайн дурын даатгуулагчдын эзлэх хувийн жин ийнхүү арай өндөр байсан болов уу.

Дээрх үзүүлэлтүүдээс гадна ажиглагдаж буй нэг эерэг үзэгдэл бол даатгуулагч нь тэтгэвэр авагчаас илүү хурдтай өсч байгаа явдал юм. Тухайлбал, Монголд 100 тэтгэвэр авагчдад ногдох даатгуулагчдын тоо 1995 онд 144 байсан ба 2002 оныг эс тооцвол бусад онуудад ерөнхийдөө өсч, 2005 онд 251 болсон байна. Үүнийг даатгуулагч ба тэтгэвэр авагчийн тоогоор нь задлан харвал, 1995 онд 409.1 мянган даатгуулагч байсан бол 2005 онд 710.8 мянга болж жилд дунджаар 6.7 хувиар өссөн байхад, тэтгэвэр авагч нь 1995 онд 284.3 мянга байснаа 2005 онд 283.6 мянга болж ямар нэгэн өсөлт ажиглагдаагүй байна.

Ийнхүү сүүлийн жилүүдэд Монгол улсад тэтгэврийн насны хүн амын хувь харьцангуй доогуур бөгөөд аажим өсөлттэй байхад тэтгэврийн даатгалын сан алдагдалтай байгаа нь уг алдагдал тэтгэврийн даатгалын сангийн орлого бүрдэлттэй илүү их хамааралтай гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл нийт ажиллагсад даатгалд бүрэн хамрагдахгүй байгаагаас тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг бууруулахад хүндрэлтэй байж болох юм. Хэрвээ ажиллагсдыг энэхүү даатгалд бүрэн хамруулж чадсан бол уг сангийн үйл ажиллагаа ямар байж болох байсныг бодит байдалтай харьцуулан Зураг 2.6-д үзүүлэв.

Зураг 2.6 Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, бодит болон тооцоолсноор, 1995-2005 /сая төгрөг/



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 1995-2005 оны тайлан
Өөрийн тооцоо

Зургаас харахад, бүх ажиллагсдыг даатгалд хамруулж чадсан бол тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь бүрэн алга болохгүй ч гэсэн одоогийн бодит түвшингэсээ нилээн доогуур байх байсан нь харагдаж байна. Түүнчлэн бүх ажиллагсдыг тэтгэврийн даатгалд хамруулж чадсан үед тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь 2005 онд ДНБ-ий 0.5 хувьтай тэнцэх хэмжээнд байх боломжтой байсан ба энэ нь одоогийн бодит түвшингэс 4 дахин бага байжээ.

Тэтгэврийн даатгалын сангийн зарцуулалт: Монгол улсын тэтгэврийн даатгалын сан ийнхүү алдагдалтай ажиллаж ирсэн нь хэдийгээр орлого бүрдэлт талтай нэлээд хамааралтай байгаа ч даатгалын шимтгэлийн орлогыг зөв зохистой хуваарилах, зарцуулах асуудал нь мөн түүний алдагдалд нөлөө үзүүлэх нь мэдээж.

Энэхүү тэтгэврийн даатгалын сангийн зарцуулалтын асуудал нь тэтгэврийн даатгалын бодлого, хууль, эрх зүйн зохицуулалтуудтай салшгүй холбоотой. Иймд тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг бодлогын гэж нэрлэж болох зарим хүчин зүйлстэй холбон авч үзье.

2.3. Бодлогын хүчин зүйлс

Монгол Улсын “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулинд: Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насын тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насын тэтгэвэр тогтоолгон авч болно. Мөн хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажилладаг эрэгтэйчүүд 50-55, эмэгтэйчүүд 45-50 насандаа холбогдох заалтын дагуу тэтгэвэр тогтоолгох, харин дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүд 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насын тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй гэж заасан байдаг.

Энэ талаар дэлхий нийтийн жишгийг авч үзвэл, хөгжиж байгаа орнуудад тэтгэвэрт гарах стандарт нас хөгжингүй орнуудынхаас нэлээд доогуур байдаг бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд 60-64 насын хооронд байхад эмэгтэйчүүдийн хувьд хөгжиж буй орнуудын 94 хувьд нь 64 буюу түүнээс доош нас байна.

Монгол улсын хувьд жишээ болгон 2004 оны байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгосон хүн амыг нас, хүйсээр нь авч үзвэл (Хүснэгт 2.2), эрэгтэйчүүд 60-64 насандаа, эмэгтэйчүүд 50-54 насандаа тэтгэвэр тогтоолгосон хандлага хамгийн өндөр хувьтай байна. Тэтгэвэр тогтоолгосон дундаж насыг тооцож үзэхэд эрэгтэйчүүдийн хувьд 60.1, эмэгтэйчүүдийн хувьд 51.8 нас байгаа ба үүнийг хүн амын төрөлтөөс тооцсон дундаж настай жишвэл эрэгтэйчүүд 1.54 жил, эмэгтэйчүүд 15.9 жил тэтгэвэр авахаар байгаа нь харьцангуй тэнцвэртэй бус байна. Нөгөө талаас шинээр тэтгэвэр тогтоолгож буй нийт хүн амын 59 хувь нь 60 нас хүрэхээсээ өмнө тэтгэвэр тогтоолгож байгаа нь тэтгэврийн ачааллыг нэмэгдүүлэх бас нэг шалтгаан болж байна гэж болно.

Xүснэгт 2.2. 2004 онд шинээр тэтгэвэр тогтоолгосон хүн амын хувь, насыны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	Хүйс		Нийт тэтгэвэр тогтоолгосон хүн ам
	Эмэгтэй	Эрэгтэй	
45 - 49	2.0	0.0	1.0
50 - 54	75.0	2.0	44.0
55- 59	20.0	6.0	14.0
60 - 64	2.0	90.0	40.0
65 +	1.0	2.0	2.0
Нийт	100.0	100.0	100.0
Тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн ажилласан дундаж хугацаа	25.4	29.3	27.0
Тэтгэвэр тогтоолгосон дундаж нас	51.8	60.1	55.4
Хүн амын дундаж наслалт /2004 оноор/	67.7	61.64	64.58

Мэдээлийн эх үүсвэр: НХХЯ, Тэтгэврийн даатгалын оногийн байдал, тулгамдсан асуудлууд, Улаанбаатар, 2005.

Дээрхээс гадна Монгол улсын хувьд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар бүрэн тэтгэврийн доод хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй, хувь тэнцүүлсэн тэтгэвэр 50 хувиас багагүй байхаар заагдсан. Ингэж зааж өгөх нь тэтгэврийн даатгалын орлого бүрдэлтээс хамаарахгүйгээр тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлдэг. Хэдийгээр энэхүү доод тэтгэврийг нэмэгдүүлэх нь иргэдийн орлогыг өсгөх, ядуурлаас хамгаалах сайн талтай ч түүнийгээ нөхөх эх үүсвэрээ шийдээгүй үед тэтгэврийн сангийн алдагдлыг эрс өсгөх төдийгүй ялгаатай цалин хөлснөөс шимтгэл төлж байгаа иргэдийн хөдөлмөрийн үнэлэмжийг бууруулснаар иргэдийн нийгмийн даатгалд итгэх итгэлийг бууруулж болзошгүй юм.

Дээрх бүх хугацааны тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг шийдвэрлэх үүднээс манай нийгмийн даатгалын систем 1999 оноос эхлэн “тэтгэврийн нэрийн данс”-нд шилжиж эхэлсэн байна. Энэ тогтолцоогоор 1960 оноос хойш төрсөн даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг түүний нэрийн дансанд хуримтлуулж байгаа тухай бичилт хийж, түүний насан туршид хуримтлуулсан хөрөнгийг тэтгэврийн наснаас хойш амьдрах дундаж хугацаанд харьцуулж, 12 сард хувааснаар сарын тэтгэврийн хэмжээг тогтоох ёстой.

Одоогоор манай улсад 1960 оноос хойш төрсөн 1038.5 мянган иргэн байна. Эдгээрийн дөнгөж 44.2 хувь буюу 458.9 мянган даатгуулагч нэрийн дансаа нээлгүүлсэн гэжээ. 2005 оны 1 дүгээр сарын 1-ны байдлаар нийт 458.9 мянган даатгуулагчийн нэрийн дансны эхний үлдэгдэл болон 2004 он хүртэл төлсөн шимтгэл нийтдээ 284 тэрбум төгрөг болж байна. Шинэ тогтолцоогоор даатгуулагчийн нэрийн дансны эхний үлдэгдэл болон тухайн жилд төлсөн шимтгэл тус бүрд хүү тооцох ёстой ба 2004 онд 3152.7 сая төгрөгийн хүү тооцжээ (НХХЯ, 2005). Гэвч манай нэрийн дансны тогтолцоо нь одоохондоо даатгуулагчийн төлсөн шимтгэлийг бодитойгоор түүний банкны харилцах дансанд хадгалж чадахгүй, хийсвэрээр хүү тооцож байгаа билээ.

Ийнхүү хэдийгээр нэрийн дансны тогтолцоонд шилжсэн хэдий ч тэтгэврийн даатгалын сан нь хөрөнгө мөнгөний дутагдалтай учир нэрийн дансанд хуримтлуулах боломжгүй өнөөгийн шимтгэлийн орлого болон улсын шууд татаасаар зарлагаа нөхөн үндсэндээ хуваарилалтын тогтолцоо хэвээр үргэлжилж байна гэж хэлж болохоор байна. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь буураагүй, хуримтлал нь хийсвэр учир төрөлтийн тэсрэлтийн үед төрөгсөд (*baby-boomer*) тэтгэврийн насанд шилжин, хүн амын дундаж наслалт нэмэгдэн, насжилт явагдах үед тэтгэврийн даатгалын сангийн ачаалал улам нэмэгдэх төлөвтэй байна.

2.4. Тэтгэврийн даатгалын санд нөлөөлогч хүчин зүйлсийн шинжилгээ

Хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн зарим хүчин зүйлс тэтгэврийн даатгалын сантай хэрхэн холбогдож байгааг ерөнхий байдлаар өмнөх хэсэгт авч үзлээ. Эдгээр хүчин зүйлсийн өөрчлөлт нь үнэхээр тэтгэврийн даатгалын сангийн орлого-зарлага, алдагдалтай харилцан хамааралтай байгаа эсэхийг статистик шинжилгээгээр шинжилж үзье. Хүн ам зүйн үзүүлэлтүүдийн хувьд насны бүтцийн өөрчлөлт, хүн ам зүйн ачаалал зэргийг; эдийн засгийн үзүүлэлтийн хувьд иргэдийн хөдөлмөр оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэгчдийн дундах хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын хувийн жин болон даатгуулагч, тэтгэвэр авагчдын хувь зэрэг үзүүлэлтийг авч үзсэн.

Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал хэрхэн өөрчлөгдөж байгаад хүн ам зүйн хүчин зүйлийн үзүүлэх нөлөөг дараах мэдээлэлд үндэслэн авч үзье.

Хүснэгт 2.3. Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал ба хүн амын насны бүтцийн үзүүлэлтүүд, 1995-2005

Он	Хөдөлмөрийн насны хүн амын хувь	Тэтгэврийн насны хүн амын хувь	Даатгуулагч, тэтгэвэр авагчийн харьцаа	Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, ДНБ-д эзлэх хувиар
	X ₁	X ₂	X ₃	Y
1995	56.24	5.71	144	1.34
1996	57.04	5.67	203	1.06
1997	57.91	5.65	265	0.63
1998	58.73	5.67	256	1.05
1999	58.99	5.24	254	1.29
2000	60.76	5.45	247	1.45
2001	61.79	5.48	243	1.88
2002	61.87	5.49	208	1.97
2003	61.87	5.49	237	1.67
2004	61.87	5.49	244	2.20
2005	61.87	5.49	251	1.95

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 1995-2005 оны тайллан; УСГ, “Статистикийн эмхтгэл”, 2000, 2003, 2005; УСГ, “Монгол улс зах зээлд”, 2002

Хүн ам зүйн хүчин зүйлс болох хөдөлмөрийн насны ба тэтгэврийн насны хүн амын хувь, тэтгэвэр авагч даатгуулагчийн харьцааны тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нөлөөлөх нөлөөллийг дараах тэгшитгэлээр илэрхийлье:

$$Y = b_0 + b_1 X_1 + b_2 X_2 + b_3 X_3 \quad \text{Энд,}$$

Y - тэтгэврийн даатгалын сангийн ДНБ-д эзлэх хувь

X₁ - хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин

X₂ - тэтгэврийн насны хүн амын хувийн жин

X₃ - 100 тэтгэвэр авагчид ногдох даатгуулагчийн харьцаа

1995-2005 оны мэдээнд тулгуурлан тэгшитгэлийн **b₀**, **b₁**, **b₂**, **b₃** коэффициентүүдийг хамгийн бага квадратын аргаар үнэлж тэгшитгэлийг байгуулбал,

$$Y = -7.636 + 0.22X_1 - 0.41X_2 - 0.008X_3$$

R=0.939 R²=0.882(0.832) SE=0.19723 F=17.477 K₁=3 K₂=7 F_{signif}=0.001 гэж гарч байна.

Тэгшитгэлийн олон хүчин зүйлийн корреляцийн коэффициент 0.939 ба детерминациийн коэффициент 0.882 байгаа нь эдгээр хүчин зүйлийн хоорондын хамаарал хүчтэй, хувьсагчид хамтдаа тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд 88.2 хувийн нөлөөтэй байгааг харуулж байна.

Тэгшитгэлийн стандарт алдаа нь 0.19723 байгаа ба хамаарлыг статистик шалгуураар шинжилж үзье. Тэгшитгэлийн үл хамаарах хувьсагчид бүгд хамаарах хувьсагчид ямар ч хамааралгүй гэсэн тэг таамаглал (H₀: b₁= b₂= b₃=0) болон түүний өрсөлдөгч таамаглал болох хамааралтай (H₁: Коэффициентүүд бүгд тэгээс ялгаатай) гэсэн таамаглалууд дэвшүүлж F статистикаар шалгахад F=17.477 гарсан нь 95 хувийн үнэний магадлалтай, K₁, K₂ чөлөөний зэрэг бүхий хүснэгтийн ажиглалтын утга болох 4.35-аас их болж тэг таамаглал няцаагдав. Өөрөөр хэлбэл, сонгож авсан үзүүлэлтүүд хоорондоо хамааралтай байна.

Энэхүү тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь хөдөлмөрийн насны хүн амаас урвуу, тэтгэврийн насны хүн амаас шууд хамааралтай байх ёстой байтал шинжилгээгээр эсрэгээр батлагдсан байна. Энэ нь хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин нэмэгдсэн хэдий ч хөдөлмөр оролцоо хангалтгүй, хөдөлмөр эрхлэгчдийн дунд даатгуулагчийн хувийн жин нэмэгдэхгүй байгаагаас хамаарч байж болох юм. Нөгөө талаар үүнийг батлах нэг хүчин зүйл бол тэтгэвэр авагчид ногдох даатгуулагчийн харьцаа (100 тэтгэвэр авагчид) мөн. Энэ харьцаа нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдалтай сөрөг хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, тэтгэвэр авагчдад ногдох даатгуулагчийн харьцаа өсснөөр тэтгэврийн даатгалын сангийн алдагдлын хувь нь буурах юм. Тиймээс хичнээн хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин нэмэгдсэн ч даатгуулагч өсөхгүй бол тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буурахгүй гэж хэлж болохор байна.

Харин одоо тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь эдийн засгийн хүчин зүйлсээс хэрхэн хамаарч байгааг дараах мэдээлэлд үндэслэн шинжилж үзье.

**Хүснэгт 2.4. МУ-ЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АЛДАГДАЛ БА ХӨДӨЛМӨР ОРОЛЦООНЫ
ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 1995-2005**

Он	Хөдөлмөр эрхэлж буй хүний тоонд даатгуулагчийн эзлэх хувь	ХОТК	ХАА-н салбарт ажиллагсдын хувь	Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал, ДНБ-д эзлэх хувиар
	X ₁			Y
1995	54	68.5	46.1	1.34
1996	73.5	68	46.5	1.06
1997	79.8	67.4	48.9	0.63
1998	76.5	67	49.7	1.05
1999	76.5	66.7	49.5	1.29
2000	77.7	62.9	48.6	1.45
2001	75.8	62.2	48.3	1.88
2002	62.7	62.7	44.9	1.97
2003	68.8	64.5	41.8	1.67
2004	71.2	64.4	40.2	2.20
2005	73.4	62.3	40.2	1.95

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 1995-2005 оны тайллан;

УСГ, "Статистикийн эмхтгэл, 2000, 2003, 2005; УСГ, "Монгол улс зах зээлд", 2002

Эдийн засгийн хүчин зүйлс болох ажиллагсдын тоонд даатгуулагчийн эзлэх хувь, хөдөлмөр оролцооны түвшин болон хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын хувь нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нөлөөлөх нөлөөллийг дараах тэгшитгэлээр илэрхийлье:

$$Y = b_0 + b_1 X_1 + b_2 X_2 + b_3 X_3 \quad \text{Энд,}$$

Y - тэтгэврийн даатгалын сангийн ДНБ-д эзлэх хувь

X₁ - хөдөлмөр эрхэлж буй хүний тоонд даатгуулагчийн эзлэх хувь

X₂ - хөдөлмөр оролцооны түвшин

X₃ - хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын эзлэх хувь

1995-2005 оны мэдээнд тулгуурлан тэгшитгэлийн **b₀**, **b₁**, **b₂**, **b₃** коэффициентүүдийг хамгийн бага квадратын аргаар үнэлж тэгшитгэлийг байгуулбал,

$$Y = 13.561 - 0.018X_1 - 0.134X_2 + 0.045X_3$$

R=0.920 R²=0.847(0.781) SE=0.22481 F=12.914 K₁=3 K₂=7 F_{signif}=0.003 гэж гарч байна.

Тэгшитгэлийн олон хүчин зүйлийн корреляцийн коэффициент 0.920 ба детерминациийн коэффициент 0.847 байгаа нь эдгээр хүчин зүйлийн хоорондын хамаарал хүчтэй, хувьсагчид хамтдаа тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд 84.7 хувийн нөлөөтэй байгааг харуулж байна.

Тэгшитгэлийн стандарт алдаа 0.22481 байгаа ба хамаарлыг статистик шалгуураар шинжилж үзье. Тэгшитгэлийн үл хамаарах хувьсагчид бүгдээрээ хамаарах хувьсагчтай ямар ч хамааралгүй гэсэн тэг таамаглал (H₀: b₁= b₂= b₃= 0) болон түүний өрсөлдөгч таамаглал болох хамааралтай (H₁: Коэффициентүүд бүгд тэгээс ялгаатай) гэсэн таамаглалууд дэвшиүүлж F статистикаар шалгахад F=12.914 гарсан нь 95 хувийн үнэний магадлалтай, K₁, K₂ чөлөөний зэрэг бүхий хүснэгтийн ажиглалтын утга

болов 4.35-аас их болж тэг таамаглал няцаагдав. Өөрөөр хэлбэл сонгож авсан үзүүлэлтүүд хоорондоо хамааралтай байна.

X_1 ба X_2 хувьсагчуудын өмнөх коэффициентуудын утга сөрөг гарсан нь эдгээр хувьсагчид тэтгэврийн даатгалын сангийн алдагдалтай сөрөг хамааралтай болохыг харуулж байгаа юм. Тухайлбал, X_1 буюу хөдөлмөр эрхэлж буй хүний тоонд даатгуулагчийн эзлэх хувь буурах нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нэмэгдүүлэх юм. X_2 буюу хөдөлмөр оролцооны түвшингийн бууралт мөн тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нэмэгдүүлэх ба эсрэгээр, иргэдийн хөдөлмөр оролцоог нэмэгдүүлснээр сангийн алдагдлыг бууруулж болохоор байна. Харин X_3 буюу хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын хувь өндөр байх нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдал өндөр байхад нөлөөлж байна.

Дүгнэлт, зөвлөмж

Дэлхийн улс орнуудын практикаас харахад тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нь хөдөлмөрийн насын хүн амын хувийн жин буурч буй, насжилтын түвшин өндөртэй улс орнуудад илүү ажиглагдаж байгаа юм. Хэдийгээр сүүлийн 10 гаруй жилд Монгол улсын хүн амын насын бүтэц харьцангуй тааламжтай /хөдөлмөрийн насын хүн амын хувь нэмэгдэж, тэтгэврийн насын хүн амын хувь багасч байгаа/ нөхцөлд байгаа ч тэтгэврийн даатгалын сангийн алдагдал жилээс жилд нэмэгдэж түүнийг нөхөх зорилгоор улсаас олгож буй татаас мөн өсч байна. Түүнчлэн хөдөлмөрийн насын хүн амын хувь өссөнтэй холбоотойгоор тэтгэвэр авагчдаасаа даатгуулагчдын тоо илүү өсч байгаа хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн алдагдал буурахгүй байсаар байна. Энэ нь тэтгэврийн даатгалын сангийн алдагдал эдийн засгийн болон бодлогын хүчин зүйлстэй илүү холбоотой гэдгийг харуулж байна.

Эдийн засгийн талаас авч үзвэл 100 хүнд ногдох эдийн засгийн идэвхтэй хүн амын хувь (ХИЕК) 1995 оноос хойш байнга нэмэгдэж ирсэн ч нийт хүн амын дөнгөж гуравны нэг гаруй хувийг эзэлж байгаа ба тэдгээр хүмүүс бүрэн хэмжээгээр тэтгэврийн даатгалд хамрагдаж чадахгүй байна. Нийгмийн даатгалын тухай хуулинд заагдсанаар манай улсын ажиллагсдын багагүй хувийг эзэлдэг хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон малчид сайн дурын даатгалд хамрагдах боломжтой байгаа ба тэдний энэ төрлийн даатгалд хамрагдсан байдал маш хангалтгүй байна. Эдгээр нөхцлүүд нь Монгол улсын тэтгэврийн даатгалын сангийн орлогын бүрдэлтэд сөргөөр нөлөөлж, цаашилбал алдагдал буурахгүй байхад нөлөөлж байна.

Бодлогын талаас нь дүгнэвэл, манай улсын хүн амын тэтгэвэрт гарах насын талаарх хуулийн заалт ижил түвшингийн хөгжилтэй орнуудынхтай ойролцоо байгаа хэдий ч янз бүрийн шалтгаанаар эрт тэтгэвэрт гарах хандлага өндөр байна. Энэ нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах хугацааг уртасгах замаар тэтгэврийн даатгалын сангийн зарлагыг нэмэгдүүлэхэд хүргэж байгаа юм. Нөгөө талаас Монголд эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 6 орчим жилээр доогуур байгаа хэдий ч тэтгэвэрт гарч буй дундаж нас нь 9 жилээр орой байгаа нь харьцангуй тэнцвэргүй үзүүлэлт мөн. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага хугацаанд шимтгэл төлж байгаа боловч удаан хугацаанд тэтгэвэр авч байгаа нь хуваарилалт шударга бус байгааг харуулж байна.

Тэтгэврийн бодлого “хуваарилалтын тогтолцоо”-оос “хуримтлалын зарчим бүхий тогтолцоо” руу шилжиж байгаа хэдий ч хуримтлалын тогтолцоо нь тэтгэврийн шимтгэлийг хийсвэрээр хуримтлуулж байгаа тул жинхэнэ утгаараа бүрэлдэж чадахгүй байна. Иймд Монгол улсын хүн ам зүйн шилжилттэй холбоотойгоор цаашид 1960-70-аад оны өндөр төрөлтийн үеийн хүн ам тэтгэврийн насанд бөөнөөрөө ирэх үед тэтгэврийн даатгалын сангийн үйл ажиллагаа улам ч хүндрэлтэй байдалд орж болох юм.

Түүнчлэн тэтгэврийн хэмжээг тогтоох арга нь иргэний төлсөн шимтгэлээсээ бус, харин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдаатай байгаа нь тэтгэврийн даатгалын сангийн орлого өсөөгүй байхад зарлага өсөх өөр нэг шалтгаан болж байна.

Судалгааны ажлын дээрх гол дүгнэлтүүдэд үндэслэн, тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг бууруулахад дараах арга хэмжээнүүдийг анхаарах нь чухал гэж үзэж байна. Үүнд:

1. Хүн амын насны бүтцийн зохистой байдал буюу “Хүн ам зүйн цонх”-ыг сайн ашиглаж хүн амын хөдөлмөр оролцоог нэмэгдүүлснээр шимтгэл төлөгч болох ажиллагчид, ажил олгогчдын тоо хэмжээг нэмэгдүүлэх;
2. Тэтгэврийн даатгалын санд даатгуулагчдын хамрах хүрээг өргөтгөх; Үүний тулд, тухайлбал малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан тусгай нэр төрлийн тэтгэврийн даатгал гаргах замаар тэдний даатгалд хамрагдах байдлыг нэмэгдүүлж болох юм.
3. Нэг хүнд ногдох тэтгэврийн хэмжээг бууруулахгүйгээр тэтгэврийн даатгалын сангийн зарлагыг багасгах; Үүний тулд, тухайлбал эмэгтэйчүүдийн тэтгэвэр тогтоолгох насыг аажмаар нэмэгдүүлэх гэх мэт бодлогын зоригтой алхмуудыг хийж болно.
4. Тэтгэврийн хэмжээг тогтоох аргачлалаа сайжруулах; Тухайлбал, тэтгэврийн доод хэмжээг шууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй биш, харин инфляци, хэрэглээний үнийн индекстэй уялдуулан тогтоох шаардлагатай.
5. Хүн амын дунд даатгалд хамрагдалтын ач холбогдлыг сурталчлах, таниулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, энэ талаарх ойлголт, хандлагад нь эерэг өөрчлөлт оруулах; Үүний тулд хүмүүс нийгмийн даатгалд хамрагдалт, түүний ач холбогдлын талаар ямар мэдлэг, хандлагатай байгааг тусгайлсан судалгаагаар судалж ч болох юм.

Ашигласан материал

Азийн хөгжлийн банк, 2001. Хөгжлийн санхүүгийн салбарын бэхжүүлэлт төслийн илтгэл

Abel, A.B. 2001b. Will Bequest Attenuate the Predicted Meltdown in Stock Prices When Baby Boomers Retire. Review of Economics and Statistics, Vol.83(4)).

Cangiano et al. 1998. “Social security reforms”

Д.Цэрэнпил, 2003. Монголын хүн амын сэтгүүл № 8, “Нийгмийн даатгалын тогтолцоо түүнийг боловронгуй болгох асуудал”, Монголын Хүн Ам ба Хөгжил нийгэмлэг, Улаанбаатар

ЕАКМ, 2005, Енбек жане Алеуметтик Коргау Министер, www.enbek.kz

Karuna Pal and others, 2005. Issues in social protection: Can low income countries afford basic social protection? Discussion paper 13

Л.Мөнхзул, 2004. “Нийгмийн даатгалын тогтолцоо, тулгамдаж буй бэрхшээлүүд, цаашдын чиг хандлага” илтгэл

Lee Ronald, 2003, University of California, Center for Economics and Demography aging, “Stochastic forecast of the Social Security Trust Fund”

“Монгол улсын хөдөлмөрийн тухай“ хууль

МХАХН, ХАССТ, НҮБ-ын ХАС, “Монголын хүн амын сэтгүүл” дугаар 6, 8, 10, 11

Насжилтийн асуудлаарх үйл ажиллагааны олон улсын стратеги, 2002

Нийгмийн даатгалын багц хууль

НХХЯ, 2005. Тэтгэврийн даатгалын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд

НХХЯ, 2003. Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг

Патрик Вейс, Майкл Кохан, 2003. Тэтгэврийн шинэчлэлийг Монгол улсад хэрэгжүүлэх хувилбаруудын үнэлгээ

ҮНДЕГ, нийгмийн даатгалын сагуудын орлого зарлагын 1995-2005 оны тайлан тэнцэл

Үндсэн чиглэл, 1999, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл

ҮСГ, Дэлхийн банк ба UNDP, 2004, Өрхийн орлого, зарлага амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан 2002-2003 он

ҮСГ, 2000. “Монгол Улсын хүн ам ХХ-р зуунд”, Үндэсний Статистикийн Газар, Улаанбаатар

ҮСГ, 1998, 2000, 2003, 2005. “Статистикийн эмхтгэл”, Үндэсний Статистикийн Газар, Улаанбаатар

ҮСГ, 1979, 1989. “Монголын хүн амын динамик эгнээ”, Үндэсний Статистикийн Газар, Улаанбаатар

ҮСГ, 2002. “Монгол улсын хүн амын хэтийн тооцоо”, Үндэсний Статистикийн Газар, Улаанбаатар

ҮСГ, UNDP, Дэлхийн банк, 2004. “Өрхийн орлого, зарлага амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан 2002-2003 ”

Ч. Дагвадорж, 2005. “Нийгмийн хамгаалал: онол- арга зүй, туршлага, харьцуулалт”

US, General Accounting Office, 2004. Retirement Income, Implications of Demographic trends for Social Security and Pension Reform.